

Коронавирусын эсрэг вакцины заавар (Нэмэлт тунд ((2023 оны хавраас эхлэн хийх)) хамрагдахад)

Коронавирусын эсрэг вакцины тухай

Уг вакцин нь үндэсний болон орон нутгийн засаг захиргааны коронавирусын (SARS-CoV-2) эсрэг вакцинжуулалтын хөтөлбөрийн нэг хэсэг юм. Энэхүү вакцинжуулалтыг Засгийн газраас санхүүжүүлж байгаа бөгөөд хүссэн хүн бүрүнэ төлбөргүй хамрагдах боломжтой.

Вакцины үр нөлөө, тарих арга

Энэ вакцин нь Moderna компанийн омикроны эсрэг 2 валент вакцин (өмнөх вариант (анхдагч вариант) болон омикроны вариант BA.1 эсвэл BA.4-5) юм. Коронавирусын халдварт өвчний хүндрэлээс урьдчилан сэргийлэх, халдвараас урьдчилан сэргийлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэнэ.

BA.1-ийн эсрэг 2 валент вакцин нь 18-с дээш насныханд хийсэн клиник туршилтаар, хийлгэснээс хойш 28 хоногийн дараах саармагжуулах эсрэг биетийн түвшин нь өмнөх дан валенттай вакцин (анхдагч вариант) -ы нэмэлт тунтай харьцуулахад түүнтэй ижил буюу илүү гэдэг нь баглагдсан зэргээс өвчлөл, хүндрэлээс тодорхой хэмжээгээр урьдчилан сэргийлэх боломжтой гэж үзэж байна. Мөн, BA.4-5-ын эсрэг 2 валент вакцины нэмэлт тун нь мутант вариантын эсрэг дархлаа үүсгэх болон урьдчилан сэргийлэх үр дүнтэй нь клиник бус туршилтаар баглагдсан бөгөөд BA.5-ыг багтаасан бусад мутант вариантуудаас өргөн хүрээнд урьдчилан сэргийлэх үр дүнтэй гэж үзэж байна. Гэхдээ 12-с 17 насныханд хийсэн нэмэлт тунгийн клиник туршилтын дүнд тулгуурлан өмнөх 1 валент вакцины нэмэлт тунд 12-с дээш насныхныг хамруулахаар хүрээг тэлсэнээр омикроны вариантын эсрэг 2 валент вакцины нэмэлт тун хийх хүрээ мөн адил тэлсээр байна.

| | |
|--|---|
| Худалдааны нэр | Spikevax™ булчинд тарих (2 валент: анхдагч вариант/омикроны вариант BA.1 эсвэл анхдагч вариант/микрон вариант BA.4-5) |
| Үр нөлөө | SARS-CoV-2-ээс үүдэлтэй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх |
| Вакцинжуулалтын давтамж ба хоорондын зай | 1 дэх удаа (өмнөх тарилга хийснээс хойш 3 сараас дээш хугацаа өнгөрсний дараа) * Булчинд тарих |
| Вакцинжуулалтын хамрах хүрээ | 1 дэх удаа (1, 2 дахь удаагийн) тарилга хийсэн ①65-с дээш насныхан, ②12-с 65 хүртэлх насны суурь өвчтэй болон хүндрэх эрсдэл өндөртэй гэж эмчийн үзсэн хүмүүс, ③эмнэлгийн байгууллагын ажилтнууд болон настны асрамжийн газар зэргийн ажилтнууд |
| Тарилгын тоо, тун | Нэг тун 0.5 мл-ээр нийт 1 удаа |

- Энэхүү вакциныг өмнө хийлгэсэн вакцины төрлөөс үл хамааран хийлгэх боломжтой ч анхны тунгаар хийлгэх боломжгүй.
- Уг вакцины тунг хийлгэсэн ч өвчлөлөөс бүрэн гүйцэд хамгаалахгүй тул үргэлжлүүлэн халдвараас урьдчилан сэргийлэх зохих арга хэмжээ шаардлагатай.

Вакцинжуулалтад хамрагдах боломжгүй хүн

Уг вакциныг доорх хүмүүст хийх боломжгүй. Та өөрийгөө доорх аль нэг заалтад хамаарна гэж үзвэл вакцины өмнөх үзлэгийн үеэр эмчид заавал мэдэгдэнэ үү.

- Илт халуурч буй хүн (*1)
 - Хүнд цочмог өвчтэй хүн
 - Энэ вакцины найрлагад хэт цочромтгой (*2) өвчний түүхтэй хүн
 - Дээрхээс гадна вакцин хийлгэхэд тохиромжгүй байдалд байгаа хүн
- (*1) Илт халуурч буй гэдэг нь 37.5°C ба түүнээс дээш халуунтай байхыг хэлнэ. Гэвч халуун нь 37.5°C-ээс бага ч жирийн үеийн биеийн халуунаас их байна гэж үзвэл халуурч буйд тооцно.
- (*2) Анафилаксийн шок болон бүх биеийг хамарсан арьс, салст бүрхэвчийн шинж тэмдэг, шуугиантай амьсгал, амьсгалын гажуудал, зүрх дэлсэх, цусны даралт буурах зэрэг анафилаксийн шок гэж үзэх хам шинжүүд.

Өмнө нь вакцин хийлгэхэд эдгээр шинж тэмдэг илэрсэн хүмүүст ижил найрлагатай вакцинаар нэмэлт тун хийх боломжгүй.

Вакцин хийлгэхэд анхаарвал зохих хүн

Дараах заалтад хамаарах хүмүүс энэ вакциныг хийлгэхдээ анхаарах шаардлагатай. Та өөрийгөө доорх аль нэг заалтад хамаарна гэж үзвэл вакцины өмнөх үзлэгийн үеэр эмчид заавал мэдэгдэнэ үү.

- Антикоагулянт эмчилгээ хийдэг, тромбоцитопени буюу цус бүлэгнэлтийн эмгэгтэй
- Өмнө нь дархлал хомсдол гэж оношлогдсон, эсвэл төрөл төрөгсөд нь удмын дархлал хомсдолын өвчтэй хүн байгаа бол
- Зүрх, бөөр, элэг, цусны эмгэг болон өсөлтийн бэрхшээл зэрэг суурь өвчтэй
- Өмнө нь вакцин хийлгэсний дараа 2 хоногийн дотор харшлын шинж тэмдэг, тухайлбал халуурах, бүтэн биеийн тууралт зэрэг шинж тэмдгүүд илэрч байсан бол
- Таталт өгч байсан бол
- Энэ вакцины найрлагад харшилтай байж болзошгүй бол

Хэрэв та жирэмсэн, жирэмсэн байж болзошгүй эсвэл хөхүүл бол вакцины өмнөх үзлэгийн үеэр эмчид заавал мэдэгдэнэ үү. Хэдийгээр хариуцсан эх барих эмэгтэйчүүдийн эмчийн зөвшөөрөлгүй байсан ч урьдчилсан үзлэгийн эмч вакцин хийлгэх боломжтой гэж үзсэн тохиолдолд вакцин хийлгэж болно. Хэрэв та өмнө нь эмийн бодист хэт мэдрэг эсвэл харшлын урвал үзүүлж байсан бол вакцины өмнөх үзлэгийн үеэр эмчид заавал мэдэгдэнэ үү.

(Ар талд үргэлжлэл бий)

Вакцин хийлгэсний дараа анхаарах зүйлс

- Вакцин тариулсны дараа доод тал нь 15 минут (өмнө нь анафилаксийн шок зэрэг хүнд хэлбэрийн харшлын өвчнөөр өвдөж байсан, дотор муухайрч, ухаан алдаж байсан хүмүүс дор хаяж 30 минут) тухайн газартаа хүлээх ба биед ямар нэг өөрчлөлт мэдэгдвэл яаралтай эмчид хандана уу. (Энэ нь гэнэтийн хариу урвалд яаралтай хариу арга хэмжээ авах боломжийг олгоно.)
- Тариулсан газрыг цэвэр байлгах ба вакцин хийлгэсэн тухайн өдөр усанд ороход асуудалгүй боловч тариулсан газрыг үрж угаах болохгүй. Мөн хийлгэсний дараа бие тавгүйтвэл амран, усанд орохоос тагталзах зэргээр байдлаа ажиглаарай.
- Жирийн амьдралын хэв маягаа үргэлжлүүлж болох ч хүчтэй дасгал хөдөлгөөн хийх, согтууруулах ундаа хэтрүүлж хэрэглэхээс зайлсхийнэ үү.

Гаж нөлөөний

- Гаж нөлөөнд голчлон тариулсан газар өвдөх, толгой өвдөх, үе мөч болон булчин өвдөх, ядрах, хүйт оргих, халуурах зэрэг орно. Мөн ховор тохиох ноцтой гаж нөлөөнд шок эсвэл анафилаксийн шок орно. Гэхдээ энэ вакцин нь шинэ төрлийн вакцин тул өдийг хүртэл илэрч байгаагүй бусад шинж тэмдэг илэрч болно. Хэрэв вакцин хийлгэсний дараа ямар нэг зовиур илэрвэл вакцины эмч эсвэл өөрийн үзүүлдэг эмчээсээ зөвлөгөө аваарай.
- Маш ховор тохиолдолд вакцин хийлгэсний дараа зүрхний булчингийн үрэвсэл болон зүрхний үнхэлцэг хальсны үрэвсэл үүссэн байх магадлалтай жишээг мэдээлсэн. Вакцин хийлгэсний дараа хэд хоногийн дотор цээжээр өвдөх, зүрх дэлсэх, амьсгал давчдах, хавагнах зэрэг шинж тэмдэг илэрвэл эрүүл мэндийн байгууллагад яаралтай хандаарай.
- Маш ховор тохиолдолд, мРНК вакцин хийлгэсний дараа Гийен-Барре хам шинж бүртгэгдэж буй. Хийлгэсний дараа гар хөл сулрах, бадайрах зэрэг шинж тэмдэг илэрвэл эрүүл мэндийн байгууллагад яаралтай хандаарай.

Вакцинаас үүдэх эрүүл мэндийн хохиролд үзүүлэх тусламжийн тогтолцооны тухай

Вакцин нь эрүүл мэндэд хохирол (өвчин үүсгэх, хөгжлийн бэрхшээл үлдээх зэрэг) учруулж ч болно. Нэн ховор тохиох боловч үүнийг бүрэн арилгах боломжгүй учир тусламжийн тогтолцоо байдаг.

Коронавирусын эсрэг вакцины улмаас эрүүл мэндэд хохирол учирсан тохиолдолд Дархлаажуулалтын тухай хуулийн дагуу тусламж (эмчилгээний зардал, хөгжлийн бэрхшээлийн тэтгэвэр олгох)-ид хамрагдах боломжтой. Өргөдөлд шаардлагатай процедурын талаар оршин суугчийн бүртгэлтэй хотын захиргаанаас лавлана уу.

Коронавирусын халдварт өвчний тухай

SARS-CoV-2 халдварын үед шинж тэмдгүүд нь халуурах, ханиалгах зэрэг нийтлэг ханиадны шинж тэмдгүүдтэй төстэй байдаг. Хөнгөн хэлбэрээр тусаж эдгэрдэг хүмүүс олон байдаг ч хүндэрвэл амьсгал давчдах зэрэг уушгины хагталгаа даамжирч, улмаар үхэлд хүрэх тохиолдол ч бий.

Одоо хийгдэж буй коронавирусын эсрэг вакцины (Moderna компанийн омикрон вариантын эсрэг 2 валент вакцин (BA.1/BA.4-5)) онцлог

Энэхүү вакцин нь РНК-мессенжер (мРНК) вакцин бөгөөд SARS-CoV-2 (хуучин вариант (анхдагч вариант) болон омикрон вариант BA.1 эсвэл BA.4-5) холболтын уураг (вирус хүний эсэд нэвтрэхэд шаардагдах уураг)-ийн бүрдүүлэгч болох мРНК-ийг липидийн мембранд агуулсан бүтээгдэхүүн болно. Энэ вакцинаар мРНК-г хүний эсэд оруулахад мРНК-ийн үндсэн дээр эсүүдэд вирусын холболтын уураг үүсэж, холбох уураг болон эсийн дархлааны хариу урвалын эсрэг биетүүдийг үүсгэдэг бөгөөд энэ нь SARS-CoV-2-ийн халдвараас урьдчилан сэргийлдэг гэж үздэг.

Энэхүү эмийн бодис нь дараах найрлагатай.

| | |
|-------------------|---|
| Идэвхтэй найрлага | <ul style="list-style-type: none">◇ Эласомеран (хуучин вариант (анхдагч вариант) -ын бүтэн хэмжээний холбох уургийг кодчилдог мРНК)◇ Имеласомеран эсвэл дэйвсомеран (аль аль нь омикрон вариант BA.1 эсвэл BA.4-5-ын бүтэн хэмжээний холбох уургийг кодчилдог мРНК) |
| Нэмэлт | <ul style="list-style-type: none">◇ SM-102: гептадекан-9-ил 8-((2-гидроксил этил) (6-оксо-6-(ундецилокси) гексил) амино) октан хүчлийн эфир◇ Холестерол◇ DSPC: 1,2-дистеоройл-sn-глицеро-3-фосфохолин◇ 1,2-димиристоил-рак-глицеро-3-метил полиоксиэтилен (PEG2000-DMG)◇ Трометамол◇ Трометамолын давс◇ Мөсөн цууны хүчил◇ Ацетат натри гидрат◇ Сахароз |

Коронавирусын вакцины талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны вэбсайтаас харна уу.

Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Корона Вакцин

Хайх

Хэрэв та вэбсайт үзэх боломжгүй бол оршин суугаа хотын захиргаа руу хандана уу.

